



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН  
ТУГИЙН ОДОНТ  
**АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2024 оны 08 сарын 05-өдөр

Дугаар A/35

Улаанбаатар хот

Улаанбурханы эрсдэлээс сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, 16.5.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.6, 24 дүгээр зүйлийн 24.6.3, 35 дугаар зүйлийн 35.5, Арьсны өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбурхан өвчнийг илрүүлэх, сэжиглэх, ялган оношлох, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийх, хэрэгжилтийг хангаж ажиллах багийг хавсралтад дурдсан гишүүнтэйгээр байгуулсугай.

2. Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгслийг тасралтгүй хангах, ариутгал, халдвартгүйтгэлийн бодис болон шаардлагатай эмчилгээнд хэрэглэх эм, тариа, хүчилтөрөгчийн хангамжийг бүрдүүлж ажиллахыг эм зүйн алба (М.Дэлгэрцэцэг)-нд, унаа, шатахууны нөөцийг бүрдүүлж ажиллахыг Аж ахуйн алба (Ү.Даваахүү)-нд тус тус даалгасугай.


3. Албан хаагчдыг Улаанбурханы вакцинаар дархлаажуулах арга хэмжээг яаралтай зохион байгуулж, сэргийлэх, мэдээ, мэдээлэл, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Тархвар судлаач (Э.Нарантуяа), Хүний нөөцийн алба (Ж.Өүлэндарь)-нд тус тус үүрэг болгосугай.

4. Улаанбурхан өвчний сэжигтэй тохиолдол бүрийг Халдварт өвчин судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн яаманд мэдээлэхийг Захирлын туслах, бичиг хэргийн ажилтан (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

5. Тушаалыг нийт албан хаагчдад танилцуулж, тушаалтай танилцсан тухай тэмдэглэл хөтлөхийг Хүний нөөцийн алба (Ж.Өүлэндарь)-нд даалгасугай.

6. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны 3-5/901 дугаартай албан бичгийн хавсралтад заасан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг тасаг, албадын дарга, албан хаагч нарт үүрэг болгосугай.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал (Б.Батцэцэг), Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Амарзаяа)-д тус тус үүрэг болгосугай.



Арьсны өвчин судлалын үндэсний төвийн  
Захирлын 2024 оны 08 дугаар сарын 05-ний  
өдрийн A/35 дугаар тушаалын хавсралт

Э020031090  
ХТУ4419 9104224

**Улаанбурхан өвчнийг илрүүлэх, сэжиглэх, ялган оношлох,  
эмнэлгийн тусlamж үйлчилгээний бэлэн байдал,  
хариу арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах баг**

### Эмнэл зүйн баг

Ахлагч:	Б.Батцэцэг	Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал
Гишүүд:	Г.Цогзол	Поликлиникийн тасгийн эрхлэгч
	Б.Жавхлант	Сувилахуйн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	М.Сарантуяа	Эрчим эмчилгээ, яаралтай тусlamжийн тасгийн их эмч
	Б.Сүхболд	Лабораторийн тасгийн их эмч
	Б.Лхагвасүрэн	Сургалтын албаны дарга
Нарийн бичиг:	Ж.Булган	Чанарын албаны дарга

### Халдвар хяналт сэргийлэлт, тандалт, судалгааны баг

Ахлагч:	Э.Нарантуяа	Тархвар судлаач
Гишүүд:	Ж.Өүлэндарь	Хүний нөөцийн албаны дарга
	Б.Энхсайхан	Поликлиникийн тасгийн их эмч
	А.Дулмаа	Лабораторийн тасгийн Их эмч
	Н.Оюунзул	Поликлиникийн тасгийн Ахлах сувилагч
	Х.Эрдэнэтуюяа	Хүүхдийн тасгийн Ахлах сувилагч
	Д.Оюунчимэг	2 дугаар тасгийн Ахлах сувилагч
	Х.Хэрлэн	Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн
Нарийн бичиг:	Ү.Саруул	Чанарын менежер

### Санхүү, нөөцийн баг

Ахлагч:	Ц.Амарзаяа	Эдийн засагч
Гишүүд:	Ү.Даваахүү	Аж ахуйн албаны дарга
	Ю.Болормаа	Хоол үйлдвэрлэлийн тасгийн эрхлэгч
	М.Дэлгэрцэцэг	Эм зүйч
Нарийн бичиг:	Г.Энхжаргал	Нягтлан бодогч